



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/ИИ

Ховд

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын Алаг толгой баг, Мөст сумын Баянхайрхан баг, Үенч сумын Нарийн гол баг, Мөнххайрхан сумын Борт багт малын гоц халдварт Шүлхий өвчин оношлогдон, тархалтын хүрээ нэмэгдэж байгаа тул халдварыг таслан зогсоох, голомтыг устгах, халдвар дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн Ховд аймгийн хэмжээнд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Малын гоц халдварт Шүлхий өвчин гарсан голомтын бүсийн айл өрхүүдийн хөл хөдөлгөөнийг бүрэн зогсоож, 2021 оны 8 дугаар сарын 26-аас эхлэн 2021 оныг дуустал гадны аймаг, сум болон Ховд аймгийн бусад бүх сумдаас өөрийн сумын нутаг дэвсгэрт ямар ч малыг отор нүүдэл, худалдаа, арилжаа, уралдаан, хүнсний болон бусад зориулалтаар оруулах, нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэхийг бүрэн хориглож, Булган, Мөст, Үенч, Мөнххайрхан сумдаас гарах, орох гол зам, цэгүүдэд шалган нэвтрүүлэх пост байгуулж, байнгын ажиллагаанд оруулж ажиллахыг Булган сумын Засаг дарга /Ж.Дамдинбазар/, Мөст сумын Засаг дарга /Б.Баасандорж/, Үенч сумын Засаг дарга /Э.Уртнасан/, Мөнххайрхан сумын Засаг дарга /Б.Батболд/, Цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Булган, Мөст, Үенч, Мөнххайрхан сумдаас болон зүүн, төвийн бүсийн аймгуудаас амьд мал хүлээн авахаас татгалзах, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл, тээвэрлэлт, тууварлалтанд хатуу хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Өвчин илэрсэн сумдын голомтын бүсээс гадагш гарах хүн мал, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүрэн хориглож, хяналтын постуудад хүн хүч, техник хэрэгсэл нэмэгдүүлж, гамшгийн үеийн шуурхай удирдлагаар ханган, хэв журам сахиулж ажиллахыг Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Зэвсэгт хүчний 123 дугаар анги /хурандаа Х.Энхболд/, Хилийн 0130 дугаар анги /хурандаа Г.Баярхүү/, сумдын Засаг дарга нар, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга нарт тус тус даалгасугай.

5. Малын гоц халдварт Шүлхий өвчин гарсантай холбогдуулан Булган, Мөст, Үенч, Мөнххайрхан сумдын нутаг дэвсгэрт отор нүүдэл хийхийг хориглох шийдвэр гаргаж мөрдүүлэн, малчид, иргэдэд сэрэмжлүүлэг, мэдэгдэл хүргэж, хил залгаа орших сумдын нутагт отор нүүдэл, тээвэр, тууврын гол цэгүүдээ тогтоож пост гаргаж, хяналт тавьж ажиллахыг Алтай сумын Засаг дарга /Х.Түмэндэлгэр/, Цэцэг сумын Засаг дарга /З.Мөнхзориг/, Дуут сумын Засаг дарга /С.Ганзориг/ нарт үүрэг болгосугай.

6. Малын гоц халдварт Шүлхий өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээ авах, хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлж, тархвар зүйн судалгаа, халдваргүйжүүлэлт, дархлаажуулах, халдварыг таслан зогсоох, голомтыг устгах үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/, Булган сумын Засаг дарга /Ж.Дамдинбазар/, Мөст сумын Засаг дарга /Б.Баасандорж/, Үенч сумын Засаг дарга /Э.Уртнасан/, Мөнххайрхан сумын Засаг дарга /Б.Батболд/ нарт үүрэг болгосугай.

7. Шүлхий өвчний голомтыг устган хорио цээрийн дэглэмийг татан буулгатад өвчний голомттой сумдаас бусад сум руу амьд мал тууварлах, тээвэрлэх, худалдах, хүлээн авахыг аймгийн хэмжээнд хориглож, эрүүл сумдаас аймгийн иргэдийн хүнсний хэрэгцээнд Мал эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан гэрчилгээтэй мал, мах нэвтрүүлэхийг зөвшөөрсүгэй.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН